



**“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХК-ИЙН “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХЯНАН БАТАЛГААЖИЛТ**

2025.06 сар

SHAREHOLDERS

НЭГДҮГЭЭР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Төлөөлөн удирдах зөвлөл нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтэцтэй, үр дүнтэй бүтэц байна

		Үнэлгээ	Тайлбар
1	<i>1.1. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмаар төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.</i>	2	ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг 2022 оны 6 сарын 28 –ны өдрийн 03 дугаар тогтоолын 1-р хавсралтаар баталсан. Танай газраас ирүүлсэн даалгаврын дагуу ТУЗ-ын 2024 оны 2 сарын 6-ны өдрийн 03 тоот тогтоолоор 3 нэмэлт өөрчлөлт оруулав. Журам болон тогтоолыг хавсаргав. /2024.02.06-ны 2024/03 тоот/ ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны тайлан хүргүүлэв.
2	<i>1.2. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна.</i>	2	ТУЗ-ийн 2022 оны 6 сарын 28 –ны өдрийн 03 дугаар тогтоолын 3-р хавсралтаар “Нэр дэвшүүлэх хорооны журам, 4-р хавсралтаар”, “Залгамж халааны бодлого”-ыг тус тус батлав. ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд тусгасан.
3	<i>1.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, өөрийн цахим хуудсанд байршуулна.</i>	2	ТУЗ болон түүний дэргэдэх хороод, ТУЗ-ийн дарга, гишүүдийн жилийн ажлын гүйцэтгэлийг үнэлсэн, үнэлгээг хүргүүлэв, Хувьцаа эзэмшигчийн ээлжит 32 дугаар хурлын тайланд мэдээллийг тусгаж ээлжит хуралд танилцуулсан. Хурлын мэдээллийг Хөрөнгийн биржийн цахим хаягт байршуулж, өөрийн компанийн цахим хуудсанд байршуулсан.
4	<i>1.4. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримт бичигтэй байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэр зэрэг асуудлыг тусгана.</i>	2	ТУЗ-ийн 2022 оны 6 сарын 28–ны өдрийн 03 дугаар тогтоолын 2-р хавсралтаар “Аудитын хорооны үйл ажиллагааны журам”, 3-р хавсралтаар “Цалин урамшууллын хорооны журам”-ыг баталсан. “Аудитын хорооны үйл ажиллагааны журам”-ын 2-р хэсэгт аудитын хорооны гишүүдэд тавигдах шаардлагыг тусгасан. ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 3-р зүйлд ТУЗ-ийн гишүүдэд тавигдах шаардлагыг тусгасан.

5	1.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.	2	ХЭ-ийн 2024 оны ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүдийг сонгосон бөгөөд 2024 оны 8-р сард чиглүүлэх сургалтыг зохион байгуулсан. ТУЗ-ийн гишүүдэд зориулсан 2025 оны жилийн сургалтын төлөвлөгөөг боловсруулан баталж уг төлөвлөгөөний дагуу сургалтыг зохион байгуулсан. Сургалтын хөтөлбөрийг хавсаргав
6	1.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.	2	ТУЗ-ийн нарийн бичгийн даргын 2025 оны эхний хагас жилийн ажлын тайланг хүргүүлэв. Тайланг хавсаргав.
ХОЁРДУГААР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ-ҮҮРЭГ Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ			
7	2.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болоод төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.	2	ТУЗ-ийн дэргэдэх хороодын 2024 оны ажлын тайланг хавсаргав. ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, комплайнсын ажилтны мэдээллийг хавсаргасан анкетын дагуу ирүүлэх шаардлагыг хангав. 2024 оны 2 сарын 6-ны ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай тогтоолын 2-т зааснаар ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүд байхаар тогтоосоны дагуу ТУЗ-ийн гишүүдийн олонх буюу 5 гишүүн нь хараат бус гишүүн байна. / 2024.04.29 03/24 Тогтоолыг хавсаргав./
8	2.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.	2	Аудитын хорооны үйл ажиллагааны журмыг 2022 оны 6 сарын 28 –ны өдрийн 03 дугаар тогтоолын 2- р хавсралтаар баталсан. Шаардлагатай тохиолдолд Гүйцэтгэх удирдлагын ажилтнуудыг хуралд оролцуулдаг болно. Аудитын хорооны тайланг хавсаргав.
9	2.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин	2	Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх цалин, урамшууллын үйл ажиллагааны журмыг 2015 оны 8 сарын 16-ны өдрийн 05 дугаар тогтоолын хавсралтаар журмын батласан. 2023 оны 3-р сарын 20-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар Ажилтнуудад цалин хангамж олгох журам, ажлын гүйцэтгэлийг

	урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.		үнэлэх урамшуулал олгох журмыг батлан мөрдүүлж байна. 2025 оноос журмын дагуу инфляцад уялдуулан ТУЗ-ийн гишүүдэд болон ажилтнуудын цалинг 20 хүртэл хувиар нэмэгдүүлэн олгож байна.
10	2.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.	2	ТУЗ-ийн 2015 оны 8 сарын 16-ны өдрийн 05 дугаар тогтоолын хавсралтаар баталсан журмын 10,6 дугаар зүйлд зохицуулснаар уг шаардлагыг бүрэн хангаж байгаа болно. Өмнө хүргүүлсэн журамд өөрчлөлт ороогүй болно.
11	2.5. Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршилага бүхий бүрэлдэхүүнтэй байна.	2	Хувьцаа эзэмшигчийн ээлжит 31 дугаар хурлын 2024 оны 04 сарын 29 –ны 03/24 тоот тогтоолоор томилогдсон ТУЗ нь тухайн салбарын мэдлэг чадварыг хуримтлуулсан гишүүдээс бүрдсэн бөгөөд шинээр сонгох орон тоонд хууль зүйн өндөр мэдлэгтэй нэр дэвшигчдийг дэвшүүлэн хувьцаа эзэмшигчдийн саналаар сонгосон.
ГУРАВДУГААР ЗАРЧИМ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ			
Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн байдлыг хангана			
12	3.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	2	2022.06.28-ны өдрийн ТУЗ-ын хурлын 03/2022 дугаартай тогтоолоор баталсан журмын 1-р хавсралтаар баталсан журмын 9.8.2 дугаар бүлэгт нарийвчлан зохицуулж, мөрдөн ажиллаж байна.
13	3.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.	2	Кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг компанийн цахим хуудсанд бүрэн байршуулсан.

14	3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.	2	2024 оны жилийн эцсийн аудитлагдсан тайлан, үйл ажиллагааны тайлан, Аудитын тайланг МХБ, СЗХороонд хуулийн хугацаанд тус тус хүргүүлж цахим хуудаст байрлуулсан
----	--	---	---

ДӨРӨВДҮГЭЭР ЗАРЧИМ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

Төлөөлөн удирдах зөвлөл нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана

15	4.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, хөндлөнгийн аудиторыг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, журмын хэрэгжилтэд хяналт тавина.	2	Засаглалын баримт бичиг, дүрэм журам зааврыг шинээр боловсруулан ТУЗ-ийн 2022 оны 6 сарын 28 –ны 03 тоот тогтоолын 9.8.1-т баталгаажуулан хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд Хөрөнгийн биржийн цахим хуудаст байрлуулсан.*
16	4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.	2	Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд Фискал аудит компанийн захиарал Д.Алтантөгс оролцсон бөгөөд ХЭ – дээс ямар нэг асуулт гараагүй болно. 2025 оны ХЭХ-д хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгсөнтэй холбогдох нотлох баримт ирүүлэх “Фискал аудит” ХХК-ийг ТУЗ-ийн ээлжит хурлаар сонгож гэрээ байгуулан ажиллаж байна. 2024 оны санхүүгийн тайлан дүгнэлт гаргасан.
17	4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж тэдгээрт орсон өөрчлөлтийг тухай бүр мэдэгдэнэ.	2	ТУЗ-ийн 2024оны 2-р сарын 6 –ний өдрийн 2024/05 тоот тогтоолоор жилийн санхүүгийн тайланд дүгнэлт гаргуулахаар Фискал аудит компанийг сонгосон бөгөөд Аудитын дүгнэлтийг ХЭХ-д мэдээлж, Хөрөнгийн бирж болон компанийн цахим хуудсанд байршуулсан. 2024 оны гэрээг дүгнэж Фискал аудит компанийн гэрээг сунган ажиллаж байна.

ТАВДУГААР ЗАРЧИМ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Төлөөлөн удирдах зөвлөл нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина

18	5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.	2	ТУЗ-ын 2022 оны 06 дүгээр сарын 28-ний өдрийн 03 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар “Эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө”-г баталж мөрдүүлэн хяналт тавьж байгаа.
19	5.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.	2	ТУЗ-нь 02 тоот тогтоол гаргаж ТУЗ-ийн гишүүдийг хороодод хуваарилж Эрсдэлийн хорооны гишүүнээр ТУЗ-ийн гишүүн Х.Цэндбаяр, Х.Баттуул М.Золжаргал нар томилогдож, дагуу ТУЗ-ын 2022 оны 06 дугаар сарын 28-ний өдрийн 03 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан “Эрсдэлийн удирдлагын бодлого журам”-ыг батлуулан Компанийн эрсдэлийн төлөвлөгөөний биелэлтэнд хяналт тавьж ажиллаж байна. Мөн “Чанарын менежментийн тогтолцоо” ISO 9001:2015 хэрэгжилтийн хүрээнд салбар бүрийн эрсдэлийг гарган хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.2024 онд “Чанарын менежментийн тогтолцоо” ISO 9001:2015 стандартаа дахин баталгаажуулж авсан. / Гэрчилгээ хавсаргав/
20	5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.	2	2024 оны жилийн үйл ажиллагааны тайланд компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэх талаарх мэдээллийг тусгаж, тайланг Хөрөнгийн биржийн цахим хуудас, компанийн цахим хуудсанд байршуулсан. 1.Орчны ногоон байгууламжийн талаар: Байгууллагын гадна талбайн ногоон байгууламж сайжруулах дараах ажлуудыг хийсэн. 1. Нарс, шар хуайс зэрэг мод ургамлыг тарьж арчлан ургуулсан. 2. Нийт 800 орчим мкв талбайд зүлэг арчилж цэцгийн мандал ургуулсан. 2.Нийгмийн хариуцлага, Эрүүл мэндийн хүрээнд хийгддэг, хэрэгжүүлж буй ажлууд: 1.Японы Зүрх хамгаалах төслийг ивээн тэтгэж 23 дахь жилдээ хамтран ажилласан. Энэ төсөл нь Япон улсын өндөр мэргэжлийн эмч нар Монгол Улсад ирж Зүрхний өвчтэй олон хүүхдүүдэд үзлэг оношилгоо хийж, эмчилгээ хийдэг төсөл юм. 2. 2024.04 сараас УБ хотын хүнсний хог хаягдлыг дахин боловсруулах төсөлд хамрагдан хоол үйлдвэрлэлээс гарсан хог хаягдлыг дахин боловсруулж 60кг

		орчим бордоог боловсруулж ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтэд ашиглан ажиллав. 3. “Эс И Эс Смарт Солюшн” ХХК тай хуванцар сав, лаазны хаягдал нийлүүлэх хамтын гэрээ байгуулан байгаль дэлхийгээ хамгаалахад хувь нэмрээ оруулан ажиллаж байна. 4. Нийтийн үйлчилгээнд болон ажилчдад эрүүл ахуйн шаардлага хангасан үйлдвэрийн аргаар бэлдсэн мах, махан бүтээгдэхүүнээр үйлчилдэг.
21	5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.	2 Компанийн удирдлагын үйл ажиллагааны журмын 3.1.4-т комплайнсын хяналтыг хэрэгжүүлэх асуудал тусгагдсан бөгөөд дотоод аудит болон журамд заасан албан тушаалтнууд уг үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

ЗУРГААДУГААР ЗАРЧИМ. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ

Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна

22	6.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.	2 ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшуулал зардлыг ХЭ-ийн ээлжит хурлаар баталгаажуулж 2025 оны 4-р сараас мөрдөж ажиллаж байна. ХЭ-ийн хурлын тогтоол, тушаалыг хавсаргав.
23	6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримт бичигт тусгана.	2 2025 онд одоогийн нөхцөл байдал ажиллах хүчний нөөцөөс хамааран бүтцээ шинэчлэн батлаж, Ажлын үнэлгээний системийг тогтоож, цалинг 4 шатлалаар тогтоож, ажлын үнэлгээний журам гарган мөрдөж байна. 2025 онд дээрх журмын дагуу ажиллагсдын цалинг нэмэгдүүлэн 20 хүртэл хувиар нэмэгдүүлэн шинэчлэн тогтоосон. / Тушаал хавсаргах/
24	6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.	2 Үүрэг, даалгавар: 2024 оны жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурын талаарх мэдээллийг тусгаж, тайланг компанийн цахим хуудсанд байршуулсан.

ДОЛООДУГААР ЗАРЧИМ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ

Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ

25	7.1. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.	2	2022.06.28-ны өдрийн ТУЗ-ы хурлын 03/2022 дугаартай тогтоолоор баталсан журмын 7-р хавсралтаар “Баянгол зочид буудал” ХК-ийн оролцогч талуудтай хамтран ажиллах бодлогын баримт бичгийн батлаж мөрдөн ажиллаж байна.
26	7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.	2	Үүрэг, даалгавар: 2024 оны жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаарх мэдээллийг тусгаж, компанийн цахим хуудсанд байршуулсан.
27	7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.	2	Үүрэг, даалгавар: Кодекст заасан мэдээллийг компанийн цахим хуудаст бүрэн байршуулах, кодексет нийцүүлэх ажлыг хэрэгжүүлж бүрэн байршуулсан
28	7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.	2	Компанийн Хөдөлмөрийн дотоод журмын хүрээнд эдгээр асуудлыг дэлгэрэнгүй зохицуулсан бөгөөд мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулах талаар Захиргаан Хүний нөөцийн албаны ажлын төлөвлөгөөнд тусгагдан хэрэгжүүлж байна. Энэ талаар компанийн үйл ажиллагааны тайланд тусгасан болно.
НАЙМДУГААР ЗАРЧИМ. КОМПАНИЙН СОЁЛ			
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно			
29	8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор төлөөлөн удирдах зөвлөл нь ёс зүйн	2	Компани нь үүсгэн байгуулагдаад 60 аад жилийн туршлагадаа үндэслэн компанийхаа үнэт зүйлс, алсын хараагаа тодорхойлж, зорилго зорилт, чанарын бодлогоо тодорхойлог жил жилийн бизнес төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж байна. Бидний АЛСЫН ХАРАА: “Баянгол зочид буудал” ХК нь зочлохуйн үйлчилгээний салбарт тэргүүлэх чиглэл баримтлан, гадаад дотоодын байгууллагуудтай хамтран ажиллаж, олон улсын үйлчилгээний стандарт,

	дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.		стандарт, дэвшилтэт шинэ үйлчилгээ, техник, төхөөрөмж ашиглан, чадварлаг баг, ажилтантайгаар “Баянгол брэнд”-ийн үйлчилгээг буй болгоно.Компани үүсэн байгуулагдсан 60 жилийн ойгоо тэмдэглэх тухай төлөвлөгөө гарган ТУЗ өөр батлуулж, 2024-2025 онд хэрэгжүүлж ажиллалаа.
30	8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг төлөөлөн удирдах зөвлөл, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үлээгчийн” тогтолцоотой байна.	2	Компанийн дотоод хяналтын тогтолцоогоор дамжуулан хууль бус үйлдэл гарахаас сэргийлэх, гарсан бол олж илрүүлэх, таслан зогсоох арга хэмжээ авах зохицуулалттай болно.
31	8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.	2	Ёс зүйн дүрэмд авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжихгүй байх талаар тусган хэрэгжүүлж байна.
ЕСДҮГЭЭР ЗАРЧИМ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ			
Компани болон төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана			
32	9.1. Компани хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудад зориулан өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан тухай бүр хүргэнэ.	2	Кодекст заасан мэдээллийг компанийн цахим хуудаст бүрэн байршуулах, кодекст нийцүүлэх ажлыг хэрэгжүүллээ.
33	9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба хөрөнгө оруулагчидтай харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.	2	“Баянгол зочид буудал” ХК-ийн хөрөнгө оруулагч талуудтай хамтран ажиллах бодлогын баримт бичгийн баталж мөрдөн ажиллаж байна.
34	9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.	2	Хувьцаа эзэмшигчдийн хурлыг тухай бүр хууль ёсны дагуу зарлан хуралдуулахдаа тэдний эдлэх эрхийг бүхий л байдлаар хангаж, хувьцаа эзэмшигчдийн оролцоо, идэвхийг дэмжиж ажилладаг. Хурлаар хэлэлцэх асуудлаа урьдчилан танилцуулж мэдээллийн сувгуудыг ашиглан ХЭ –дэд мэдээллээ хүргэж ажиллаа.

35	9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтэцтэй холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.	2	Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд Компанийн тухай хуульд нийцүүлэн хүргэдэг болно
36	9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба түүний хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.	2	Тайлангын хугацаанд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдээгүй болно.
	ДҮН	72	100 хувь